



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/145

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монголын зохиолчдын эвлэлийн болон “Болор цом-2017” яруу найргийн наадмын тэргүүн шагналт Ховд аймгийн Дуут сумын уугуул иргэн, Ховд аймгийн зохиолчдын Алтай салбарын гишүүн, Ховд уран бүтээлийн нэгдлийн гүйцэтгэх захирал Мөнгөнхүүгийн Отгонбаярын Монголын уран зохиол, яруу найргийн салбарт гаргасан амжилт бүтээл, орон нутагт урлаг, уран зохиол, яруу найргийг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмэр, хөдөлмөрийн үр дүнг өндөрөөр үнэлэн орон сууцны дэмжлэгт 30.0 сая төгрөгийг олгосугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулах 30.0 сая төгрөг /гучин сая/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 5.24-д баталсан “Чадварлаг Ховдчууд” хөтөлбөрийн арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/145 Ch

02 00656